



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/250

Булган

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан Ойн хортны тэмцлийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр зөвлөмж, Монгол улсын Сангийн яамны 2019 оны 04 сарын 30-ны өдрийн 6-1/2650 дугаар албан бичгийн дагуу “Гранд форест” ХХК-тай 2 дугаар багцад 49 928 200 /дөчин есөн сая есөн зуун хорин найман мянга хоёр зуу/ төгрөгөөр, 3 дугаар багцад 109 170 100 /нэг зуун есөн сая нэг зуун далан мянга нэг зуу/ төгрөгөөр тус тус гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай.

2. “Гранд форест” ХХК-ийн ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Гранд форест” ХХК /Б.Жавхлантагс/-д үүрэг болгосугай.

4. Гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд “Гранд форест” ХХК нь ирүүлсэн саналын дагуу орон нутгийн ажилгүй иргэдээс багц тус бүрт 15 ажиллах хүч ажиллуулж буй эсэхэд хяналт тавихыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар /Н.Батжаргал/-д даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190271